



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/641

Булган сум


Гэрээ шууд байгуулах  
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV/05 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгт үйлчлүүлэгчдийн чих, хамар, хоолойн эмчилгээнд нэн шаардлагатай мэс заслын тоног төхөөрөмжийг 15,101,500 (арван таван сая нэг зуун нэг мянга таван зуу) төгрөгөөр “Аму мед” ХХК-тай хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Нэгдсэн эмнэлэг (Д.Зоригтбаатар)-т үүрэг болгосугай.

2. Санхүүжилтийг “Эрүүл мэнд” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0324010885